

# ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН

## 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮН

2026.06.23

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний холбогдох стратегийн зорилгуудын хүрээний 26 зорилтын 37 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна. Тайлан дахь зорилтын дугааруудын ард хаалтанд батлагдсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний харгалзах дугаарыг тусгав.

Тус газрын гүйцэтгэлийн тайланг "Журам батлах тухай" Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.4, 2.5-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хүрэх түвшин нь 01-12 сар (жилийн) болж заасан арга хэмжээг хагас жилийн байдлаар үнэлэхдээ зорилтот түвшинг 50%-иар хуваан авч, гүйцэтгэлтэй харьцуулан тооцлоо. Үнэлгээ хийхдаа тайланд дурдсан зохион байгуулалтын ерөнхий мэдээллийг бус шалгуур үзүүлэлтэд нийцсэн тоон нотлох баримтыг үндэс болгов.

Гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ холбогдох аргачлалын дагуу батлагдсан төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тус тус харгалзан үзсэн.

### Хүснэгт-1

№	Төлөвлөлтийн хэсэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь /өөрсдийн үнэлсэн/	ХШУДАГ-аас өгсөн үнэлгээ
1	Зорилт 1 (8). "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн баяжуулах үйлдвэрийн конвейрын систем	1	1	100%	100%
2	Зорилт 2 (2). Газрын хэвлийн баялгаас иргэдийн хүртэх үр өгөөжийг бодитоор нэмэгдүүлэх	1	1	70%	70%
3	Зорилт 3 (4). Стратегийн 17 орд болон томоохон ордуудын өгөөжийг ард иргэдэд шударгаар хүртээх болон үндэсний баялгийн санд орлого төвлөрүүлэх	1	6	93%	80%
4	Зорилт 4 (9). Оюутолгойн зээлийн хүүг бууруулах, менежментийн төлбөрийг багасгах хэлэлцээ хийхэд дэмжлэг үзүүлэх	1	2	90%	85%
5	Зорилт 5 (11). Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нүүрсний ордыг ашиглаж байгаа хуулийн этгээдүүдтэй төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээг тогтоох хэлэлцээ хийх	1	1	100%	80%
6	Зорилт 6 (12). Эрдэнэтийн овоо ордын үүсмэл ордыг ашиглаж	1	1	90%	75%

	байгаа хуулийн этгээдүүдтэй төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээг тогтоох хэлэлцээ хийх				
7	Зорилт 7 (16). Монгол Улсын Засгийн газар болон "Орано Майнинг" хувьцаат компани хооронд байгуулагдсан Хөрөнгө оруулалтын гэрээнд нийцүүлэн Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтэд хяналт тавих	1	3	100%	<b>97%</b>
8	Зорилт 8 (1). ЭТТ ХК-ийн баяжуулах үйлдвэрийн конвейрын системийг ашиглалтад оруулахад удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлэх	1	1	100%	<b>90%</b>
9	Зорилт 9 (3). Тавантолгойн бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах	1	1	90%	<b>75%</b>
10	Зорилт 10 (5). Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төсөл	1	1	90%	<b>82%</b>
11	Зорилт 11 (6). Гангийн үйлдвэрлэлийн цогцолборын төсөл	1	1	90%	<b>85%</b>
12	Зорилт 12 (7). Хөтлийн цемент шохойн үйлдвэрийн бүтээн байгуулалтыг дуусгах	1	1	90%	<b>80%</b>
13	Зорилт 13 (10). Жоншны баяжуулах үйлдвэрийн төсөл	1	1	70%	<b>70%</b>
14	Зорилт 14 (13). "Нүүрс химийн цогцолбор (хөх нүүрсний үйлдвэр)" төсөл	1	1	90%	<b>85%</b>
15	Зорилт 15 (14). "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг байгуулахад дэмжлэг үзүүлэх	1	1	90%	<b>85%</b>
16	Зорилт 16 (15). "Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль", "Нийтийн өмчийн тухай хуулийн" төслүүдийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх	1	1	100%	<b>100%</b>
17	Зорилт 17 (17). Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	100%	<b>85%</b>
18	Зорилт 18 (18). Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны бүртгэл, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангуулахад	1	1	100%	<b>85%</b>

	зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих				
19	Зорилт 19 (19). Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем бий болгох, хөгжүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	1	100%	<b>85%</b>
20	Зорилт 20 (20). Төрийн өмчит зарим компаниудыг олон нийтийн хяналтад оруулах, биржээр борлуулахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	1	1	100%	<b>80%</b>
21	Зорилт 21 (21). Хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хэрэгжүүлдэг төрийн өмчит компаниудад дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааг сайжруулах	1	1	100%	<b>85%</b>
22	Зорилт 22 (22). Засгийн газрын Үндэсний хороо, зөвлөл, комиссын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг зохих журмын дагуу хянаж, ЗГХЭГ-ын саналыг бэлтгэж, удирдлагыг мэдээллээр хангах	1	2	100%	<b>95%</b>
23	Зорилт 23 (23). Томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засгийн бодлогын хувилбарыг төлөвлөх, санал боловсруулах, Засгин газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	1	2	100%	<b>93%</b>
24	Зорилт 24 (24). Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийг уялдаа, удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	1	100%	<b>90%</b>
25	Зорилт 25 (25). Иргэн, хуулийн этгээд, төрийн бусад байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, хуульд заасан хугацаанд хариу өгч, шийдвэрлэх	1	1	100%	<b>100%</b>
26	Зорилт 26 (26). ЗГХЭГ-ын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, айлчлал, уулзалт, хэлэлцээрийг хуульд нийцүүлэн зохион байгуулж, гадаад томилолтын үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэх	1	2	95%	<b>88%</b>
<b>Дундаж ерөнхий үнэлгээ</b>		<b>26</b>	<b>35</b>	<b>94.1%</b>	<b>85.5%</b>

## Хүснэгт-2

Газар, хэлтэс	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	85 буюу түүнээс дээш хувь бол "бүрэн хангалттай" (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшинд нь хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд нь бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн)	70-85 хүртэл хувь бол "хангалттай" (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд нь бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах)	70 хүртэл хувь бол "хангалтгүй" (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотолгоотой.)
ТХГХАГ	26	35	17	9	0

### ДҮГНЭЛТ

Төсөл хөтөлбөр, гадаад харилцаа, хамтын ажиллагааны газраас 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг **94.1%** хувиар үнэлж ирүүлснийг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж **85.5%** хувиар үнэлэв.

Үнэлгээнд хамарсан 26 зорилтоос "бүрэн хангалттай" ( $\geq 85\%$ ) — 17 зорилт, "хангалттай" (70-85%) — 9 зорилт, "хангалтгүй" ( $< 70\%$ ) — 0 зорилт тус тус авсан. Зорилт 3.1 (4.1), 3.6 (4.6) нь холбогдох хуулийн орчин бүрдэх хүртэл хэлэлцээний дүгнэлт гарахгүй тул үнэлэх боломжгүй гэж тооцлоо. ХШҮДАГ-аас үнэлгээ хийхдээ тайланд дурдсан ерөнхий мэдээлэл биш шалгуур үзүүлэлт дэх тоон нотлох баримтыг шаардлага болгосон тул газрын өөрийн үнэлгээнээс доогуур үнэлгээ авсан зорилтуудын тоо нэмэгдсэн.

#### ХШҮДАГ-аас нарийвчилсан үнэлгээнд анхаарсан үндэслэл:

- Шалгуур үзүүлэлт нь "тийм/үгүй" буюу тоон хэмжигдэхүүн байхад тайланд "дэмжлэг үзүүлсэн", "холбогдох мэдээллээр хангасан" гэх ерөнхий тодорхойлолт бичигдсэн нь шалгуурын шаардлагыг хангасанд тооцоход хүндрэлтэй байсан тул тухайн арга хэмжээний үнэлгээ буурсан.
- Гэрээ, хэлцэл байгуулах зорилттой зорилтуудад (5.1, 6.1, 9.1, 15.1) бодит гэрээ байгуулагдсан эсэх, санамж бичиг гарын үсэг зурагдсан эсэхийг нотлох баримт байхгүй тул "тийм" гэж тооцоогүй.
- ТХГХАГ нь олон зорилтод шууд хэрэгжүүлэгч биш зохицуулалтын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй байсан тул гол шалгуур үзүүлэлт хангагдаагүй тохиолдолд бүрэн 100% өгөхгүй байх зарчмыг баримталсан.

#### Анхаарал хандуулах шаардлагатай зорилтуудаас дурдвал:


- Зорилт 13 (10) — Жоншны баяжуулах үйлдвэр: Хөрөнгө оруулагч сонгон шалгаруулалт үр дүнд хүрээгүй, санхүүжилтийн шийдвэр гараагүй (70%).
- Зорилт 5 (11) — Нүүрсний ордуудын хэлцэл: Зорилтот 4 хэлцэлд 0 хэлцэл баталгаажсан (80%).

- Зорилт 6 (12) — Эрдэнэтийн овоо ордын хэлэлцээ: Хуулийн орчин бүрдээгүй (75%).

### ЗӨВЛӨМЖ

- Стратегийн ордуудтай хийх хэлэлцээний дүгнэлтийг нотлох баримтжуулалтыг сайжруулах. Санамж бичиг байгуулагдсан эсэх, гарын үсэг зурагдсан эсэхийг тодорхой баримтжуулах.
- Бортээг ордын ашиглалтыг "ЭТТ" ХК-ийн өөрөө хариуцан явуулах шийдвэр гарсан тул зорилтын шалгуур үзүүлэлтийг дахин тодорхойлж, хэмжигдэхүйц болгох.
- Тайлан гаргахдаа "дэмжлэг үзүүлсэн", "мэдээллээр хангасан" гэх ерөнхий тодорхойлолтыг бус шалгуур үзүүлэлттэй нийцсэн тоон нотлох баримтыг оруулах.
- Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээг үлдсэн хагас жилийн хугацаанд эрчимжүүлэн ажиллах.

ХЯНАСАН:



ДЭД ДАРГА С.БАТБОЛД

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:



ЗАСГИЙН ГАЗРЫН РЕФЕРЕНТ  
Б.ОРГИЛ

Хавсралт

Хүснэгт-3

**ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН 2026 ОНЫ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН  
/ЗААЛТ БҮРИЙН ҮНЭЛГЭЭ/**

Арга хэмжээний д/д	Арга хэмжээний дугаар	Өөрсдийн өгсөн үнэлгээ	ХШҮ хийсэн үнэлгээ	Үнэлгээний тайлбар
<b>Зорилт 1 (8). "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн баяжуулах үйлдвэрийн конвейрын систем</b>				
1	1.1 (8.1)	100	100	Шалгуур: конвейрын систем ашиглалтад авсан эсэх (тийм/үгүй). 2026.02.08-нд ашиглалтад оруулсан — баримт тодорхой, шалгуур бүрэн хангагдсан.
<b>Зорилт 2 (2). Газрын хэвлийн баялгаас иргэдийн хүртэх үр өгөөжийг бодитоор нэмэгдүүлэх</b>				
2	2.1 (2.1)	70	70	Шалгуур: боловсруулсан бодлогын санал, дүгнэлт, танилцуулгын тоо (зорилтот 1). Зөвлөлдөх санал асуулгын асуулт боловсруулж, ЗГ хуралдаанд 2026.03.25-нд танилцуулж, Зөвлөлдөх зөвлөлөөр баталсан нь тоон үзүүлэлт хангасан. Гэвч санал асуулгын хугацаа хойшлогдсон.
<b>Зорилт 3 (4). Стратегийн 17 орд болон томоохон ордуудын өгөөжийг ард иргэдэд шударгаар хүртээх болон үндэсний баялгийн санд орлого төвлөрүүлэх</b>				
3	3.1 (4.1)	-	Үнэлэх боломжгүй	Шалгуур: ЗГ-ын түвшинд хэлэлцүүлсэн асуудлын тоо (зорилтот 1). Хэлэлцээ явагдсан ч холбогдох хуулийн орчин бүрдэх хүртэл дүгнэлт гарах боломжгүй. Үнэлэх боломжгүй.
4	3.2 (4.2)	90	80	Шалгуур: ЗГ-ын түвшинд хэлэлцүүлсэн асуудлын тоо (зорилтот 1). Нарийнсухайтын ордуудтай 3 уулзалт зохион байгуулж, зарчмын асуудлаар тохиролцоонд хүрч, Санамж бичгийн бэлтгэлийг хангасан. Гэвч Санамж бичиг байгуулагдсан тухай баримт байхгүй, хуулийн орчин бүрдээгүй.
5	3.3 (4.3)	90	75	Шалгуур: ЗГ-ын түвшинд хэлэлцүүлсэн асуудлын тоо (зорилтот 1). Мардай, Дорнод, Гурванбулагийн ураны ордуудтай 2026.05.07-нд уулзалт зохион байгуулж, харилцан ойлголцолд хүрсэн.
6	3.4 (4.4)	100	90	Шалгуур: ЗГ-ын түвшинд хэлэлцүүлсэн асуудлын тоо (зорилтот 1). Бүрэнхаан, Төмөртэйн овоо ордуудтай ЕС-ын оролцоотой уулзалт зохион байгуулж, компаниуд хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн.
7	3.5 (4.5)	90	75	Шалгуур: ЗГ-ын түвшинд хэлэлцүүлсэн асуудлын тоо (зорилтот 1). Цагаан суваргын ордтой холбоотой 10 гаруй техникийн уулзалтад дэмжлэг үзүүлсэн. Гэвч Засгийн газрын хуралдаанд нь танилцуулсан баримт байхгүй, дэмжлэг үзүүлэх үүрэг гүйцэтгэсэн.

8	3.6 (4.6)	-	Үнэлэх боломжгүй	Шалгуур: Засгийн газрын түвшинд хэлэлцүүлсэн асуудлын тоо (зорилтот 1). Бороогийн алтны ордын хэлэлцээ хоцрогдолтой, хуулийн этгээдийн идэвх сул, өгөөжийн бүтцийн аргачлал тодорхойгүй. Тооцооллын баримт байхгүй, хуулийн орчин бүрдээгүй. Үнэлэх боломжгүй.
<b>Зорилт 4 (9). Оюутолгойн зээлийн хүүг бууруулах, менежментийн төлбөрийг багасгах хэлэлцээ хийхэд дэмжлэг үзүүлэх</b>				
9	4.1 (9.1)	90	85	Шалгуур: зээлийн хүүг бууруулах тохиролцоонд хүрсэн эсэх (тийм/үгүй). 14 албан бичиг боловсруулж, 4 удаа хуралдаж, 8 удаа хэлэлцээ хийсэн — зохион байгуулалт сайн. Менежментийн зардлыг 2 дахин бууруулахаар тохиролцсон боловч зээлийн хүүг бууруулах шалгуур (тийм/үгүй) хангагдаагүй.
10	4.2 (9.2)	90	85	Шалгуур: зээлийн хүүг бууруулах тохиролцоонд хүрсэн эсэх (тийм/үгүй). ЕС-ын 94 захирамжаар нэгдсэн АХ байгуулагдаж, ажлын хэсгүүдийн уялдааг хангасан. Зээлийн хүү бууруулах хэлэлцээ үргэлжилж байна
<b>Зорилт 5 (11). Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нүүрсний ордыг ашиглаж байгаа хуулийн этгээдүүдтэй төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээг тогтоох хэлэлцээ хийх</b>				
11	5.1 (11.1)	100	80	Нарийнсухайтын ордуудтай 3 уулзалт зохион байгуулж, зарчмын асуудлаар тохиролцоонд хүрч Санамж бичгийн бэлтгэлийг хангасан.
<b>Зорилт 6 (12). Эрдэнэтийн овоо ордын үүсмэл ордыг ашиглаж байгаа хуулийн этгээдүүдтэй төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээг тогтоох хэлэлцээ хийх</b>				
12	6.1 (12.1)	90	75	"Ачит Ихт" ХХК-тай Санамж бичгийн бэлтгэлийг хангасан боловч гарын үсэг зурагдсан тухай баримт байхгүй. Хуулийн зохицуулалт бүрдээгүйгээс хоцрогдол үүссэн.
<b>Зорилт 7 (16). Монгол Улсын Засгийн газар болон "Орано Майнинг" хувьцаат компани хооронд байгуулагдсан Хөрөнгө оруулалтын гэрээнд нийцүүлэн Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтэд хяналт тавих</b>				
13	7.1 (16.1)	100	100	Шалгуур: гэрээний хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөний хувь (зорилтот 100%). 2026.01.13-нд Хувьцаа эзэмшигчийн гэрээнд гарын үсэг зурагдсан, тодорхой, нотлогдсон баримттай.
14	7.2 (16.2)	100	100	Шалгуур: гэрээний хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөний хувь (зорилтот 100%). 2026.02.13-нд гэрээ хүчин төгөлдөр болсон "мэдэгдэл"-д талууд гарын үсэг зурсан.
15	7.3 (16.3)	100	90	Шалгуур: гэрээний хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөний хувь (зорилтот 100%). 2026.06.03-нд төслийн үйл

				ажиллагааг нээсэн. Гэвч ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй, бэлтгэл шатанд байгаа тул 90% үнэлэв.
<b>Зорилт 8 (1). ЭТТ ХК-ийн баяжуулах үйлдвэрийн конвейрын системийг ашиглалтад оруулахад удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлэх</b>				
16	8.1 (1.1)	100	90	Шалгуур: баяжуулах үйлдвэрийн конвейрын системийг ашиглалтад авсан эсэх (тийм/үгүй). Систем ашиглалтад орсон — шалгуур хангагдсан. Гэвч энэ нь ТХГХАГ-ын шууд үүрэг биш, мэдээллээр хангаж дэмжлэг үзүүлсэн.
<b>Зорилт 9 (3). Тавантолгойн бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах</b>				
17	9.1 (3.1)	90	75	Шалгуур: Бортээгийн хэсэгт хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах гэрээ байгуулах (тийм/үгүй). 7 компани санал ирүүлсэн боловч шаардлага хангасан санал ирээгүй — сонгон шалгаруулалт үр дүнд хүрээгүй. Гэрээ байгуулагдаагүй тул шалгуур хангагдаагүй. Ажлын хэсгийн зохион байгуулалт хийгдсэнийг үнэлэв.
<b>Зорилт 10 (5). Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнансан төмөр замын төсөл</b>				
18	10.1 (5.1)	90	82	Шалгуур: Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан мэдээг нэгтгэн удирдлагад танилцуулсан тоо (суурь 3, зорилтот 4, хагас жилийн 2). Гүйцэтгэлийн аудитын тайланг 2026.06.15-нд хүргүүлсэн — 1 тайлан нотлогдсон. Гэвч зорилтот 2 тайланд хүрснийг нотлох баримт дутмаг. Барилгын явц 30.95% (жилийн зорилтот 70%-ийн 50%=35%-аас доогуур).
<b>Зорилт 11 (6). Гангийн үйлдвэрлэлийн цогцолборын төсөл</b>				
19	11.1 (6.1)	90	85	Шалгуур: Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан мэдээг нэгтгэн удирдлагад танилцуулсан тоо (суурь 3, зорилтот 4, хагас жилийн 2). 2026.06.17-ны ЗГ хуралдаанд танилцуулж, сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцүүлсэн. 1 нотлогдсон. Зорилтот 2 тайланд хүрэх баримт дутуу. Ашиглалт эхлүүлэх бэлтгэл шатанд байгааг харгалзан үнэлэв.
<b>Зорилт 12 (7). Хөтлийн цемент шохойн үйлдвэрийн бүтээн байгуулалтыг дуусгах</b>				
20	12.1 (7.1)	90	80	Шалгуур: Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан мэдээг нэгтгэн удирдлагад танилцуулсан тоо (суурь 0, зорилтот 1, хагас жилийн benchmark 0.5). Зураг төсөл батлагдаж, магадлалын дүгнэлт 2026.01.26-нд баталгаажсан. Гэрээний дүнгийн 8.54%-ийг санхүүжүүлсэн. Барилга эхлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээ аваагүй, бүтээн байгуулалт эхлээгүй.

<b>Зорилт 13 (10). Жоншны баяжуулах үйлдвэрийн төсөл</b>				
21	13.1 (10.1)	70	70	Шалгуур: Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан мэдээг нэгтгэн удирдлагад танилцуулсан тоо (суурь 3, зорилтот 4, хагас жилийн 2). Хөрөнгө оруулагч сонгон шалгаруулалт үр дүнд хүрээгүй, арга замаа өөрчилж санхүүжилтийн хүсэлт ТУЗ-д хүргүүлсэн шатанд байна.
<b>Зорилт 14 (13). "Нүүрс химийн цогцолбор (хөх нүүрсний үйлдвэр)" төсөл</b>				
22	14.1 (13.1)	90	85	Бүх талын дэмжлэг үзүүлж байна гэсэн боловч төслийн хэрэгжилт сул
<b>Зорилт 15 (14). "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах, холбогдох гэрээ хэлэлцээрийг байгуулахад дэмжлэг үзүүлэх</b>				
23	15.1 (14.1)	90	85	7 улсын 13 компаниас санал авч, 4 этгээдэд мэдэгдэл хүргүүлж, 2 оролцогч саналаа ирүүлж, "Эн Эф Си" компани шалгарсан. ЗГ хуралдаанаар танилцуулж, хэлэлцээг эхлүүлэх АХ байгуулсан. Гэрээ байгуулагдаагүй, хэлэлцээ дөнгөж эхэлж байгаа.
<b>Зорилт 16 (15). "Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль", "Нийтийн өмчийн тухай хуулийн" төслүүдийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх</b>				
24	16.1 (15.1)	100	100	Шалгуур: хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн эсэх (тийм/үгүй). 2025.01.08-нд УИХ-д өргөн мэдүүлсэн — тодорхой баримт, шалгуур бүрэн хангагдсан.
<b>Зорилт 17 (17). Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих</b>				
25	17.1 (17.1)	100	85	Шалгуур: ROA = 9.63%, зорилтот 10%, суурь байхгүй. Хагас жилийн = 10%×50% = 5% — гүйцэтгэл 9.63% нь давсан. Гэвч ТХГХАГ нь шууд хариуцдаггүй — зөвхөн мэдээллээр хангаж, тайланг ЗГ хуралдаанд танилцуулсан дэмжлэгийн үүрэгтэй. АХ байгуулах тушаал батлагдаагүй байгаа нь хэрэгжилт дутмаг.
<b>Зорилт 18 (18). Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны бүртгэл, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангуулахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих</b>				
26	18.1 (18.1)	100	85	Систем хөгжүүлэлтийн ажил дуусаагүй. Зохион байгуулалтын дэмжлэгийг харгалзан үнэлэв.
<b>Зорилт 19 (19). Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем бий болгох, хөгжүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх</b>				
27	19.1 (19.1)	100	85	Шалгуур: систем хөгжүүлэх, хувь (суурь 60%, зорилтот 100%, хагас жилийн 80%). 2025 онд ашиглалтад оруулсан, 2026.07.01-нд бүрэн ашиглалтад оруулахаар бэлтгэж байна. Сангийн яаманд 2026.03.26-нд танилцуулсан.

				Одоогийн хөгжүүлэлтийн байдал тодорхойлогдоогүй. 85% үнэлэв.
<b>Зорилт 20 (20). Төрийн өмчит зарим компаниудыг олон нийтийн хяналтад оруулах, биржээр борлуулахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих</b>				
28	20.1 (20.1)	100	80	Шалгуур: ажлын гүйцэтгэлийн хувь (суурь 82%, зорилтот 100%, хагас жилийн benchmark 91%). УИХ-ын тогтоолын төслийг 2025.12-д өргөн мэдүүлсэн боловч ЗГ-ын 2026.05.20-ны хуралдаанаар буцаан татан авахаар шийдвэрлэсэн. Биржээр борлуулах гол зорилт хэрэгжилтгүй болсон. Мэдээллээр хангаж ажилласныг харгалзан үнэлэв.
<b>Зорилт 21 (21). Хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хэрэгжүүлдэг төрийн өмчит компаниудад дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааг сайжруулах</b>				
29	21.1 (21.1)	100	85	Шалгуур: ашигт ажиллагааны түвшин (зорилтот Т+12%). ТУЗ-д томилогдох нэрсийг холбогдох компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэлийг хангасан. Гэвч Т+12% ашигт ажиллагааны зорилтот үзүүлэлтэд хүрсэн эсэхийг нотлох тоо байхгүй. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын ажлыг харгалзан 85% үнэлэв.
<b>Зорилт 22 (22). Засгийн газрын Үндэсний хороо, зөвлөл, комиссын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг зохих журмын дагуу хянаж, ЗГХЭГ-ын саналыг бэлтгэж, удирдлагыг мэдээллээр хангах</b>				
30	22.1 (22.1)	100	100	Шалгуур: ЗГ хуралдаанд хэлэлцүүлсэн, танилцуулсан асуудлын тоо (суурь 5, зорилтот 6, хагас жилийн 3). Нийт 10 асуудал хэлэлцэгдэж, 10 тогтоол батлагдсан, 21 хороо, зөвлөл хурлаа хийсэн — тоон баримт тодорхой, зорилтоос-аас 3 дахин их.
31	22.2 (22.2)	100	90	Шалгуур: ЗГ хуралдаанд хэлэлцүүлсэн, танилцуулсан асуудлын тоо (суурь 5, зорилтот 6, хагас жилийн 3). 21 хороо, зөвлөлийн 2026 оны төлөвлөгөөг авч нэгтгэсэн. 34 хороо, зөвлөлийн байршлын судалгааг нэгтгэсэн. Нэгтгэсэн тайлан, хяналтын баримтжуулалт дутмаг тул 90% үнэлэв.
<b>Зорилт 23 (23). Томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засгийн бодлогын хувилбарыг төлөвлөх, санал боловсруулах, ЗГ хуралдаанаар хэлэлцүүлэх</b>				
32	23.1 (23.1)	100	100	Шалгуур: ЗГ хуралдаанд хэлэлцүүлсэн, танилцуулсан асуудлын тоо (зорилтот 4, хагас жилийн 2). 10 асуудал хэлэлцүүлж, 18 шийдвэрийн баримт бичиг батлуулсан — зорилтот тооноос 2-оос 5 дахин их. Тоон баримт тодорхой.
33	23.2 (23.2)	100	85	Шалгуур: ЗГ хуралдаанд хэлэлцүүлсэн, танилцуулсан асуудлын тоо (зорилтот 4, хагас жилийн 2). Нийт 3 удаа мэдээлэл хүргэсэн. Гэвч зорилтот нь хэлэлцүүлсэн асуудлын тоо биш, үр дүнг олон нийтэд

				хүргэх ажил — тоон нотолгоо дутмаг тул 85% үнэлэв.
<b>Зорилт 24 (24). МУ-ын Засгийн газрын тогтоол, ЕС-ын захирамж, сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийг уялдаа, удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх</b>				
34	24.1 (24.1)	100	90	Шалгуур: ажлын хэсгийн зорилт хангагдсан хувь (зорилтот 90%+). Нийт 16 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, хэрэгжилтийн тайланг 2 удаа ХШҮДАГ-т хүргүүлсэн, ЕС-ын даалгаврыг хугацаанд нэгтгэсэн. 2025 оны гүйцэтгэл 91.7%. Зохион байгуулалтын үйл ажиллагааны хувьд 90% үнэлэв.
<b>Зорилт 25 (25). Иргэн, хуулийн этгээд, төрийн бусад байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, хуульд заасан хугацаанд хариу өгч, шийдвэрлэх</b>				
35	25.1 (25.1)	100	100	Шалгуур: хугацаанд нь шийдвэрлэсэн хувь 100%. 178 албан бичиг, өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж, 86 албан бичгийг боловсруулж хүргүүлсэн — тоон баримт тодорхой.
<b>Зорилт 26 (26). ЗГХЭГ-ын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, айлчлал, уулзалт, хэлэлцээрийг хуульд нийцүүлэн зохион байгуулж, гадаад томилолтын үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэх</b>				
36	26.1 (26.1)	90	85	Шалгуур: хуультогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан уулзалт, хэлэлцээрийн тоо (суурь 22, зорилтот тухай бүр, гүйцэтгэлээр). 14 уулзалт зохион байгуулсан (суурь 22-оос бага). 15 хаагчийг 7 улсад сургалтад хамруулсан.
37	26.2 (26.2)	100	90	Шалгуур: хуультогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан арга хэмжээний тоо (суурь 4, зорилтот тухай бүр, гүйцэтгэлээр). БНХАУ-д 3 аймгийн Засаг дарга нарыг сургалтад хамруулсан, Монгол-Японы Ирээдүй Санд хамтарсан санамж бичгийн төслийг боловсруулсан. Газрын дарга 3 улсын элчин сайдтай уулзалт хийсэн. Айлчлал хойшлогдсон нь гүйцэтгэлд нөлөөлсөн тул 90% үнэлэв.
<b>Нийт дундаж үнэлгээ</b>		<b>94.1%</b>	<b>85.5%</b>	Газрын өөрийн үнэлгаатай харьцуулахад бууруулсан зорилтууд: 2(60%), 3.2(75%), 3.3(70%), 3.4(85%), 3.5(70%), 4.1(80%), 4.2(80%), 5.1(75%), 6.1(70%), 7.3(90%), 8.1(90%), 9.1(55%), 10.1(75%), 11.1(80%), 12.1(70%), 13.1(50%), 14.1(75%), 15.1(80%), 17.1(80%), 18.1(80%), 19.1(85%), 20.1(75%), 21.1(85%), 22.2(90%), 23.2(85%), 24.1(90%), 26.2(90%). Зорилт 3.1, 3.6 — үнэлэх боломжгүй.